

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨДЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.6	
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЭЛЭЛТ	15
ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	
ТӨЛӨВЛӨГӨӨ	25
ДОЛОО ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31
АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ	
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..	39
ДҮГНЭЛТ.....	41

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршлын зураг	4
Зураг 2. Бутлан ангилах хэсгийн дамжлагын схем зураг	5
Зураг 3. Зам талбайг засаж буй байдал	6
Зураг 4. Сөрөг нөлөөлөл бууруулах ажлын хүрээнд тоосжил дарахын тулд зам усалж буй байдал	6
Зураг 5. Зам засвар болон усалгаа үйлчилгээний гэрээ	8
Зураг 6. “Жи Эс Эн Ди” ХХК нь өөрийн талбай дээрх худагийг хамгаалан тохижуулсан байдал	9
Зураг 7. Ус ашиглах гэрээ	12
Зураг 8. Бохир ус соруулах гэрээ	14
Зураг 9. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж буй байдал	15
Зураг 10. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулсан мод нийлүүлэх, тарих гэрээ	18
Зураг 11. Дүйцүүлэн хамгаалал хийсэн тайлангийн нүүр	19
Зураг 12. Хашааны өнгийг сэргээн засаж зэврэлтээс хамгаалж буй байдал	21
Зураг 13. Гагнуурын ажлыг гүйцэтгэж хайсыг засч буй байдал	21
Зураг 14. Булгийн эхийг тохижуулан самбар байгуулсан	22
Зураг 15. Нарны эх үүсвэртэй гэрэлтүүлэг байгуулсан	22
Зураг 16. Амрах сандал суурьлуулж байгаа байдал	22
Зураг 17. Дүйцүүлэх ажлын дараах байдал	23
Зураг 18. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ	26
Зураг 19. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтын явц	28
Зураг 20. Ажилчдын хувцас хэрэглэл авсан баримт-3150000 төгсгөл	29
Зураг 21. Ажилчдын хувцас хэрэглэл авсан баримт-480000 төгрөг	29
Зураг 22. Ажлын хувцас авсан баримт-4 380 000 төгрөг	30
Зураг 23. 2024 оны 05 сарын 01-нд авсан хөрсний сорьцны дүн	32
Зураг 24. 2024 оны 05 сарын 01-нд авсан дуу агаарын шинжилгээний дүн	33
Зураг 25. 2024 оны 04 сарын 05-нд авсан гүний худаг усны шинжилгээний дүн	34
Зураг 26. 2024 оны 10 сарын 25-нд хийсэн агаарын шинжилгээний дүн	35
Зураг 27. 2024 оны 10 сарын 25-нд авсан хөрсний сорьцын дүн	36
Зураг 28. 2024 оны 10 сарын 25-нд авсан хашаан доторх газраас авсан хөрсний сорьцны дүн	37
Зураг 29. Орчины шинжилгээний баримт	38
Зураг 30. БОМТ 2024 оны баталгааг байршуулсан баримт	40

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн солбицлын цэгүүд	3
Хүснэгт 2. “Баянгол” булгийн эхийг хашиж, хамгаалах тохижуулахад зарцуулсан зардалын тооцоо	24
Хүснэгт 3. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	27
Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээ хийлгэсэн байдал	31

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Зүүн түрүүн” нэртэй барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл


Төсөл хэрэгжүүлэгч: “Жи Эс Эн Ди” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011303123, Регистрийн дугаар: 5511577, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл: 16/M001

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, 5-18 тоот. Утас: 99132043, 99093350

Төслийн байриил: “ЖИ ЭС ЭН ДИ” ХХК-ийн эзэмшдэг 16/M001 тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Зүүн түрүүн” нэртэй талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн L-48-10 тоот хавтгайд доорх цэгүүдээр хязгаарлагдсан 95.37 га талбайг хамран оршино. Улаанбаатар хотоос Дархан-Уул аймаг руу явдаг хатуу хучилттай засмал зам талбайн зүүн хойд хэсгээр 1.5 км зайтай өнгөрдөг.

Хүснэгт 1. Талбайн солбицлын цэгүүд

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	35	14.94	47	56	11.57
2	106	35	43.02	47	56	11.57
3	106	35	45.81	47	56	1.57
4	106	35	42.3	47	55	48.08
5	106	35	53.57	47	55	47.76
6	106	35	56.77	47	56	1.74
7	106	35	53.49	47	56	11.57
8	106	35	58.72	47	56	11.57
9	106	35	58.72	47	55	31.55
10	106	35	14.94	47	55	31.55




Зураг 1. Төслийн байршлын зураг

Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим

Уурхайн жилийн хүчин чадлыг төсөл захиалагчаас ирүүлсэн техникийн даалгаварт санал болгосны дагуу жилд 200.0 мян.м³ барилгын чулуу олборлон боловсруулахаар сонгон авч ТЭЗҮ-г боловсруулсан байна.

Уурхай нь хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллах ба цаг ашиглалтын итгэлцүүр 0.85 байна гэж үзвэл хоногт нийт 8.5 цаг ажиллах юм. Жилд 4-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл нийт 184 хоног ажиллах бөгөөд 153 хоногт нь цэвэр олборлолтын үйл ажиллагаа явуулахаар тооцлоо.



Зураг 2. Бутлан ангилах хэсгийн дамжлагын схем зураг

Эцсийн бүтээгдэхүүний агуулах ба дахин ачилт

Бутлан ангилах хэсэгт чулууг 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм-ийн ширхэглэлээр бутлан ангилж ялгах ба бүтээгдэхүүний талбайгаас хэрэглэгчдэд шууд борлуулалт хийнэ. Бутлагдсан дайрганы ширхгийн бүрэлдэхүүн нь туршилтаар 0-5 мм-ийн элс 6.4%, 5-10 мм-ийн дайрга 38.0%, 10-20 мм-ийн дайрга 55.6% байна.

Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2024 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 62.67 мян.м³ хөрс хуулж, 200.0 мян.м³ барилгын чулуу олборлон 0-5мм, 5-10мм, 10-20мм фракцын бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөсөн.

Уурхайн нь гүнзгийрүүлэх чиглэлээр олборлолт явуулах тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ ОХШХ-ийн хүрээнд агаар , ус хөрс, шинжилгээ хийлгэсэн.
- ✓ Замын тоосжилтыг дарах зорилгоор тогтмол зам усалгаа хийгддэг.
- ✓ Гүний усыг хамгаалахын тулд худгийг хамгаалан байгууламж байгуулсан.
- ✓ Ус ашиглах гэрээ, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, бохир соруулах үйлчилгээний гэрээг байгуулж тайланд үзүүлэв.
- ✓ Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулж, өнгөн хөрсний овоолго байгуулж хадгалав.
- ✓ Хүнд машин механизмын явах замыг засаж тэмдэгжүүлэв.

Уурхайн карьер болон тээвэрлэх гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулав. Ажлын зургийг доор үзүүлэв.



Зураг 3. Зам талбайг засаж буй байдал



Зураг 4. Сөрөг нөлөөлөл бууруулах ажлын хүрээнд тоосжил дарахын тулд зам усалж буй байдал

ЗАМ ЗАСВАР БОЛОН УСАЛГАА АРЧИЛГААНЫ ГЭРЭЭ

2024 оны 4 сарын 16 өдөр № 24/04-16 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “Жи Эс Эн Ди” ХХК /РД: 5511577/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Ган-Эрдэнэ (цаашид “Захиалагч” тал гэнэ), нөгөө талаас /РД: ТЯ80110911/, түүнийг төлөөлж Журагат овогтой Аманбол (цаашид “Ажил гүйцэтгэгч” тал гэнэ) бид Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлүүдийг баримтлан дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг: Гэрээний зорилго

- 1.1 Ажил гүйцэтгэгч нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэр “Баруунтуруун”-д байрлах Уулын чулуу бутлан ангилах үйлдвэрийн уурхайн дотоод тээврийн тоосжилтыг бууруулах зорилгоор замын усалгаа хийх, үйлдвэрээс төв зам хүртэлх тээврийн замын тоосжилтыг арилгах, тээврийн замын болон үйлдвэрийн орчны замын засвар түүний эвдрэл гэмтлийг технологийн дагуу засаж арчлах.
- 1.2 Захиалагч нь түүнд тохирсон ажлын хөлсийг төлөх болон талуудын хооронд үүсэх бусад харилцааг энэ гэрээгээр зохицуулна.

Хоёр: Ерөнхий зүйл

- 2.1 Зам талбай усалгаа болон замын засвар үйлчилгээний машин механизмын мэдээлэл:

№	Мэдээлэл	Утга
1	Замын индүүдэгч /29-29 УР, Loton/	22 тонн
2	Зам усалгааны машин /33-82 УБК, ISUZU/	15 тн, Шүрддэг насостой

- 2.2 Энэ гэрээнд талууд гарын үсэг зурмагц хүчин төгөлдөр болно.
- 2.3 Гэрээний үйлчлэх хугацаа 2024 оны 04 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл байна.
- 2.4 Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцсоноор сунгаж болох ба сунгалтыг бичгээр үйлдэнэ.

Гурав: Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1 Тээврийн замыг тогтмол услах, замын эвдрэл гэмтлийг тухай бүрт засаж арчилж байх
- 3.2 Уурхайн тээврийн зам талбайн усалгааг технологийн дагуу хийж, арчлах
- 3.3 Тээврийн замыг бүхэлд нь хуваарийн дагуу усалгаа арчилгааг тогтмол хийн замаас гарах тоосжилтыг бууруулах /07-08 цаг, 11-12 цаг, 14-15 цаг, 18-19 цаг/
- 3.4 Ажил гүйцэтгэгчийн оператор нь Захиалагчийн өгсөн үүрэг даалгавар, зааврын дагуу ажлыг шуурхай хийж гүйцэтгэнэ.

- 3.5 Ажил гүйцэтгэгчийн оператор нь өдөр тутмын хийсэн ажлын тооцоог хөтлөн холбогдох албан тушаалтнаар хянуулж, харилцан гарын үсгээ зурж баталгаажуулна.
- 3.6 Ажил гүйцэтгэгч нь захиалагчаас машин механизмын байдал, ашиглаж буй нөхцөл, түүнийг ажиллуулж буй цаг, ачааллын байдалтай газар дээр нь танилцах эрхтэй.
- 3.7 Ажил гүйцэтгэгч нь өдрийн болон сарын нормт ажлыг тухай бүрд бүрэн гүйцэд биелүүлж ажиллах үүрэгтэй.
- 3.8 Ажлын цагаар машин механизмд эвдрэлийн улмаас гарсан сул зогсолтыг ажил гүйцэтгэгч тал хариуцах ба тухайн цаг хугацааг түрээсийн үнээс хасаж тооцно.
- 3.9 Ажил гүйцэтгэгчийн техник, оператор нь үйлдвэрийн даргын тавьсан шаардлагийг бүрэн биелүүлж ажиллана.
- 3.10 Ажил гүйцэтгэгч нь өөрийн операторын амрах, чөлөө авах г.м ямар ч шалтгаанаар операторгүй зогсох болсон тохиолдолд түрээслэгч талд 36 цагын өмнө мэдэгдэж техникийн мото цагийг тэмдэглэж баримт үйлдэн захиалагч талын эрх бүхий албан тушаалтанд түлхүүрийг хүлээлгэн үлдэнэ.
- 3.11 Ажил гүйцэтгэгч нь машин механизм болон операторын аюулгүй байдал, талын болон бусад гарч болзошгүй эрсдэлээс хамгаалж аюулгүй байдлыг ханган ХАБЭА-н дүрэм журмыг мөрдөж ажиллах, ийм төрлийн эрсдэлийг бүрэн хариуцна.
- 3.12 Ажил гүйцэтгэгч аюулгүй ажиллагааны зааварчилгааг операторт ажилд гарах бүрд өгч байх
- 3.13 Ажиллах нөхцлийн талаарх санал хүсэлтээ кэмпийн удирдлагад гаргах эрхтэй.
- 3.14 Ажил гүйцэтгэгч нь ажлын байр болон ажиллах орчны эргэн тойрныг эмх цэгцтэй, цэвэр байлгана.
- 3.15 Гэрээнд заасан түрээсийн төлбөрийг хугацаандаа төлөхийг Захиалагчаас шаардах эрхтэй.
- 3.16 Ажил гүйцэтгэгчийн шаардлага, стандартад нийцсэн дайрга түрээслэгч талаас тээвэрлэгдсэнээс хойшхи аливаа асуудлыг Захиалагч хариуцахгүй.
- 3.17 Ажил гүйцэтгэгч өөрийн техникийг зайлшгүй шаардлага үүссэний улмаас уурхайгаас гаргах болсон тохиолдолд заавал захиалагчийн удирдлагуудаас зөвшөөрөл авч гарах хуудас үйлдүүлэн гаргана.
- 3.18 Ажлын гүйцэтгэлийг тогтмол хөтлөн баримтжуулж /ажлын зураг хавсаргах/ захиалагч талын хариуцсан ажилтнаар баталгаажуулна

Дөрөв: Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулахад анхаарч, тээврийн машинуудад торон бүтээлэг хэрэглэхийг шаардах
- 4.2 Тээвэрлэлт хийх хурдыг багасгах, замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавих, хурдны хязгаарыг 40 км/ц-аас хэтрүүлэхгүй байх
- 4.3 Ажил гүйцэтгэгчийн ажилд хяналт тавьж, замын засварын ажлын захиалга өгөх
- 4.4 Гэрээний хугацаанд ажлын талбайд ирж ажиллаагүй, чөлөө авсан, зөвшөөрөлгүй амарсан ажил гүйцэтгэгчийн ажлын цагийг хасаж тооцох
- 4.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Ажил гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 4.6 Гэрээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.
- 4.7 Гэрээний нийт үнийн дүнд чанар, стандартын шаардлага хангасан дайргыг нийлүүлэх үүрэгтэй.

- 4.8 Ажил гүйцэтгэгч талд хүлээлгэн өгсөн бүтээгдэхүүний м³ хэмжээ, жолоочийн нэр, машины улсын дугаар, цаг минутыг тэмдэглэн тухай бүр баримт үйлдэж, нэг хувийг Ажил гүйцэтгэгч талын жолоочид өгнө.
- 4.9 Машин механизмыг гэрээнд заасан нөхцөл болон зориулалтын дагуу ашиглана.
- 4.10 Гэрээний 3.12 дахь тохиолдолд захиалагч үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохгүй байх шалтгаанаар ажил гүйцэтгэгчийн машин механизм дээр өөрийн операторийг ажиллуулах эрхтэй.
- 4.11 Захиалагч нь ажил гүйцэтгэгчийн операторын байрлах байр, өдрийн хоол хүнс, ажил гүйцэтгэх түлш шатахуунаар хангана.
- 4.12 Захиалагч шатахуун зарцуулалтанд хяналт тавих эрхтэй.
- 4.13 Ажил амралтын цаг, норм нормативыг биелүүлэхийг ажил гүйцэтгэгчээс шаардах.
- 4.14 Өдрийн болон сарын нормыг гүйцэд биелүүлэн ажиллахыг ажил гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.
- 4.15 Кэмпийн дотоод журам болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллахыг ажил гүйцэтгэгчээс шаардах.
- 4.16 Ээлжиндээ ажлын талбайд ажиллаагүй, сул зогссон, зөвшөөрөлгүй амарсан ажил гүйцэтгэгчийн ажлын цагийг хасах, торгох эрхтэй.
- 4.17 Ажил гүйцэтгэгчийг ажиллах нөхцөл боломжоор хангах үүрэгтэй.

Тав: Ажлын хөлс ба төлбөрийн нөхцөл

- 5.1 Зам усалгааны гэрээний төлбөр нэг өдрийн 200.000 төгрөг, нэг сарын 6.000.000 төгрөг байна. Үүнд: жолоочийн цалин, техникийн эвдрэл, гэмтлийн зардал, татвар хураамж багтана.
- 5.2 Замын эвдрэл гэмтэл засвар арчилгааны төлбөр нэг өдрийн 1.000.000 төгрөг, нэг сарын 6.000.000 төгрөг байна. Үүнд: жолоочийн цалин, техникийн эвдрэл, гэмтлийн зардал, татвар хураамж багтана.
- 5.3 Тухайн өдөр зайлшгүй ажлын шаардлага гарч захиалагч талаас хүсэлт тавьсан эсвэл зөвшөөрөл олгосон тохиолдолд ажлын цагаас илүү цагаар ажилласан ажлын хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлэн тооцно.
- 5.4 Сард хамгийн ихдээ 2 хоног нийт 48 цагийг засвар үйлчилгээний цаг болгох бөгөөд тухайн засвартай цагийг ажилласанаар бүртгэнэ. Үүнээс илүү гарсан засварын цаг нь ажиллаагүйд тооцогдох ба сул зогссон цаг тутмын хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлэн тооцож захиалагч талд торгууль төлнө. Энэхүү торгууль нь тухайн сул зогсолтыг нөхөн ажилласан машин, механизм болон операторын хөлс болно.
- 5.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр төлбөрийг 100% бартерын нөхцлөөр бүрэн төлж барагдуулна.
- 5.6 Энэхүү гэрээт ажил нь улиралын чанартай хийгддэг ажил тул улиралаас шалтгаалсан зогсолтод түрээсийн төлбөр тооцогдохгүй. Улиралын зогсолт болон эхлэх хугацааг талууд харилцан тохиролцож акт үйлдэнэ.

Зургаа. Гэрээ цуцлах, Нэмэлт өөрчлөлт оруулах

- 6.1 Аль нэг тал гэрээнд заасан үүргээ зөрчсөн, зохих ёсоор биелүүлээгүй буюу хуулинд заасан үндэслэл бий болсон хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

Хуулиас 3|4

- 6.2 Аль нэг тал гэрээний үүргээ зөрчсөн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээ цуцлагдсан бол үүргээ зөрчсөн тал гэрээ цуцлагдсаны улмаас нөгөө талдаа учирсан бодит хохирлыг хариуцан арилгана.
- 6.3 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлт болон гэрээний хавсралт нь гэрээний салшгүй нэг хэсэг болж, гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлт оруулж байгаа тохиолдолд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хууль зүйн хүчинтэй.

Долоо. Маргаан шийдвэрлэх

- 7.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.
- 7.2 Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давтагдашгүй хүчин зүйл

- 8.1 Бүх нийтийг хамарсан ус цахилгааны саатал, халдварт өвчний улмаас хорио цээр тавигдах, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хил гааль хаагдсан, үйл ажиллагаа явуулах эрхийг түтгэлзүүлсэн зэрэг, мөн байгалийн онцгой аюултай үзэгдэл, цас, бороо, үер, зам хаагдсаны улмаас үүссэн тохиолдолд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй байсан нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.
- 8.2 Дээрх нөхцөл үүссэн тохиолдолд талууд бие биендээ нэн даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд энэ хугацаанд гэрээний үйлчлэл бүрэн болон хэсэгчилэн зогсож болно.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Энэ гэрээний үндсэн эхийг 2 хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.
- 9.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ба уг нэмэлт өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцогдон энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 9.3 Талууд энэ гэрээнд дурьдсан оорийн эрхийг нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэн өгөхийг хориглоно.
- 9.4 Энэ гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжоор зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч:

“Жи Эс Эн Ди” ХХК
Гүйцэтгэх захирал Г.Ган-Эрдэнэ



Ажил гүйцэтгэгч:

Иргэн
Ж.Аманбол

Утас: 88095744

Хуулиас 4|4

Зураг 5. Зам засвар болон усалгаа үйлчилгээний гэрээ



*Зураг 6. “Жи Эс Эн Ди” ХХК нь өөрийн талбай дээрх худгийг хамгаалан тохижуулсан
байдал*

“Жи Эс Эн Ди” ХХК нь 2024 онд өөрийн талбай дээрх худгийг хамгаалан тохижуулсан ба мөн 951.88м^3 усыг унд ахуйн зориулалтаар ашигласны төлбөр 94350.34 төгрөгийг Сонгинохайрхан дүүргийн төрийн дансанд тушаахаар гэрээ байгуулжээ. Гэрээг доор үзүүлэв.

БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ТӨМӨРБААТАР

БАТЛАВ.
“ЖИ ЭС ЭН ДИ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *Бат-Ор* ЭРДЭНЭ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 05-р сарын 14-ны өдөр

Дугаар
2024-03/057

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14 дэх заалт, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2022 оны А/430 тоот захирамж, Нийслэлийн Байгаль орчны газрын 2024 оны 2024/22 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Нямхүү, Ус ашиглагчийг төлөөлж Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Улсын бүртгэлийн 9011303123, регистрийн 5511577 дугаартай “Жи эс эн ди” ХХК-ийн менежер Б.Номин нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн тооцож, 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр . Гэрээний нөхцөл:

- 2.1. Ус ашиглах зориулалт:
Уулын чулуу бутлуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, унд ахуйн хэрэгцээнд.
- 2.2 Ашиглах усны хэмжээ:
- Ундаргаар нь тооцож үзэхэд хоногт 86,4 м³ ус авч ашиглах боломжтой. Үйлдвэрлэлийн газар нь хоногт 20.0 м³ ус ашигладаг.
1 ажилтан албан хаагч хоногт 80 л ус хэрэглэнэ гэж үзвэл 29 ажилтан хоногт 2,32м³. 184 хоногт 426,88м³: 1 м² талбайг услахад 2 л ус ашиглана гэж 6 м өргөн 250 м урттай замыг услахад 3,0м³ жилд 50 удаа услахад 150.0м³ 1100 ш бут сөөг тарихад 1 сөөг 15 л ус хэрэглэнэ гэж үзвэл 25 удаа 375,0 м³ нийт 951,88 м³
- 2.3. Усны чанар, найрлага:
Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS:0900:2018”-ын шаардлага хангаж байна.
- 2.4. Усны эх үүсвэрийн:
Байршил: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, Баруун туруунд
Солбицол: 47°55'49.15"N, 106°35'45.20"E
Барилга байгууламж: Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар гаргасан 95 м гүн, өрмийн худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.
Тоног төхөөрөмж нэр марк:
Худагт LXSG-6.3 загварын 25мм голчтой усны тоолуурыг суурилуулсан.
- 2.5. Хаягдал усны хэмжээ, хаях цэгийн байршил:
Жилд 368.0 м³.
- 2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:
Жилд 552,0 кг.

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: “Данхаадай” ХХК-тай гэрээ байгуулж, бохир усыг зөөвөрлүүлж, бохирын төвлөрсөн шугамд нийлүүлдэг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөцийн бохирдлоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Байхгүй.

2.9. Усны тоолуурын: Загвар, нэр, дугаар: LXSG-6.3 загварын усны тоолуурыг суурилуулсан, 2107019705 дугаартай халуун, хүйтэн усны тоолуурыг 2024 оны 04-р сарын 16-ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгосон.

Тоолуурын тоо: 1

Тоолуур баталгаажуулалтын гэрчилгээ олгосон байгууллага огноо: Стандартчилал, хэмжил зүйн газар, 2022 оны 04-р сарын 16-ны өдөр

Тоолуурын заалт: Тоолуурын заалт 2024 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн байдлаар 00053 м³.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2024 оны усны нөөц ашигласны төлбөрийг “Усны экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай”, Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 302, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 25-ний дотор тоолуурын заалтаар тооцож /1м³ ус 99.12 төг/ төлнө.

2.10.1 Унд ахуй үйлдвэрлэлд ашигласан 951.88м³ газрын доорх ус ашигласны төлбөрт нийтдээ 94350.34./Ерөн дөрвөн мянга, гурван зуун тавин төгрөг, гучин дөрвөн мөнгө/ төгрөгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг тоолуурын заалтаар эсхүл ус ашиглах дүгнэлтээр тогтоосон дүнгээр 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Сонгинохайрхан дүүргийн Төрийн сангийн 10020090944 тоот дансанд төвлөрүүлж ажиллана.

Гурав. Талуудын эрх үүрэг.

3.1.Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

3.3 Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

3.4.Ус ашиглуулагч нь энэхүү гэрээнд заасан арга хэмжээг зохион байгуулахдаа ус ашиглагч талын удирдлагын баг болон ажилтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно.

3.5.Хэрэв үүнээс үүдэн талууд болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

3.6. Ус ашиглагч нь ус ашиглуулагч талын удирдлагын баг болон ажилтнаас энэхүү гэрээтэй холбогдуулан хөнгөлөлттэй худалдаа, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг ус ашиглагч талын эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаархи дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.
- 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.
- 4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Усан орчин ашиглуулагчийг төлөөлж:

Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын
Тохийжилт, нийтийн аж ахуйн хэлтсийн
Даргын албан үүргийг түр орлон
Гүйцэтгэгч Ж.Нямхүү

Байгаль орчин, ногоон байгууламж
хариуцсан мэргэжилтэн

Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
27 дугаар хороо
Харилцах утас: 70173213

Ус ашиглагчийг төлөөлж:

“Жи Эс Эн Ди” ХХК-ийн
менежер Б.Номин



Хаяг: Сонгинохайрхан дүүргийн
32 дугаар хороо
Харилцах утас: 95033526



Зураг 7. Ус ашиглах гэрээ

2024 онд “Жи Эс Эн Ди” ХХК-ийн бохирын гэрээг “Данхаадай” ХХК-тай байгуулан нэг удаагийн тээвэрлэлтийг 250 мянган төгрөг байхаар байгуулжээ. Гэвч 2024 оны байдлаар “Жи Эс Эн Ди” ХХК-ийн ахуйн бохир нь зайлуулах хэмжээнд хүрээгүй тул бохироо соруулаагүй байна.

БАТЛАВ.ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
“ХХК-ийн

ЗАХИРАЛ

гарын үсэг

утас: 99071905




БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
“ДАНХААДАЙ” ХХК-ийн

ЗАХИРАЛ М.ТӨМӨР

гарын үсэг

утас: 99006144



БОХИР УС СОРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2024 оны 03 -р сарын 21

№ 202314

Улаанбаатар хот

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Энэхүү гэрээг нэг талаас “G S N D” ХХК (цаашид захиалагч гэх), нөгөө талаас “ДАНХААДАЙ” ХХК (цаашид гүйцэтгэгч гэх) нар харилцан тохиролцож тус гэрээг байгуулав.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Захиалагч тал гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулна.
- 2.2. Захиалагч тал тухайн бохир ус соруулан гүйцэтгүүлэх ажлын талаарх цар хэмжээг тодорхойлж мэдээлэнэ.
- 2.3. Захиалагч тал нь төлбөрийг гэрээнд заасны дагуу дансаар хийнэ.
- 2.4. Дараагийн захиалагат ажлыг урьдчилан мэдээлэнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Гүйцэтгэгч тал цаг ямагт машин техникийг бэлэн байлгана.
- 3.2. Гүйцэтгэгч ажлын явцад тухайн машинд эвдрэл, саатал гарсан тохиолдолд хариуцлагыг өөрөө хүлээнэ.
- 3.3. Ажилд гарахын өмнө жолоочид явах маршрут, гүйцэтгэх ажлын тухай тодорхой заавар өгнө.
- 3.4. Захиалагчийн хүсэлтийн дагуу тухайн ажлыг чанартай хийж гүйцэтгэнэ.
- 3.5. Гүйцэтгэгч ажлаа хийх үедээ тус байгууллагын объектод эвдрэл учруулбал бүрэн хариуцна.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 4.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.
- 4.2. Учирсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талд нөхөн төлнө.
- 4.3. Гэрээний талаар харилцан тохиролцож, нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 4.4. Талуудын аль нэг тал нь гэрээгээ биелүүлээгүй тохиолдолд үл маргах журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдвэрлэж чадаагүй нөхцөлд Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 4.5. Талууд шаардлагатай гэж үзвэл, гэрээг аль нэг тал санал гаргаагүй тохиолдолд цаашид сунгаснаар тооцно.

ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 5.1. Төлбөрийг ХААН БАНКНЫ 502 315 0465 тоот дансанд шилжүүлнэ.
- 5.2. Бохир ус тээвэрлэх үйлчилгээний хөлсийг 250,000 төгрөгөөр тооцно
- 5.3. Бохир ус соруулснаас гадна нэмэлт үйлчилгээний төмөрлөх цэвэрлэх, бөглөө гаргах, буудуулах, худаг угаах \ хөлсийг харилцан тохиролцож тооцно.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 6.1. Энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хойш 6.2, 4.5-д заасны дагуу хугацаанд хүчинтэй байна.
- 6.2. Гэрээ байгуулсан огноо: 2024 оны 03 -р сарын 21 -ны өдрөөс 2025 оны 03 -р сарын 21 -ны өдрийг хүртэл хүчинтэй.
- 6.3. Гэрээг 1 жилийн хугацаатай хийв. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

Менежер:

гарын үсэг

утас:



Гүйцэтгэгч талыг төлөөлж:

Менежер: Х.Алтанчимэг

гарын үсэг

утас: 80976144



Зураг 8. Бохир ус соруулах гэрээ

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЭЛЭЛТ

Уурхайн 2024 онд гүнзгийрүүлэх чиглэлээр олборлолт явуулах тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх талбай байхгүй. Харин нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө болгож 8 сая 500 мянган төгрөг байршуулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн кемп дээр Тадаод ХХК-тай 5 сая 215 мянган төгрөгний гэрээ байгуулан 348 ш мод тарисан. Холбогдох гэрээ, зургийг доор үзүүлэв.



Зураг 9. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж буй байдал



О.АЛТАНСУВД



Т.ГАН-ЭРДЭНЭ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 10 дугаар
сарын 24-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

Энэхүү **АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ** (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “ТАДАОТ” ХХК Гүйцэтгэх захирал О.Алтансүвд (цаашид “**гүйцэтгэгч**” гэх), нөгөө талаас 5511577 регистрийн дугаартай “ЖИ ЭС ЭН ДИ” ХХК Гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Ган-Эрдэнэ (цаашид “**захиалагч**” гэх) (цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэнэ) нар Монгол улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

Гэрээний зүйл: Орчны нөхөн сэргээлт, мод бут тарих.

Мод бут тарих, орчныг нөхөн сэргээх ажлын нийт төлбөр тооцоо : Нөатгүй
Нөаттай 5,215,000 төгрөг.

Гэрээний хугацаа: : 2024.10.24-2024-12-30 /үргэлжлүүлэх тохиолдолд гэрээ автоматаар сунгагдана/

1. Нийтлэг заалт

- 1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн даалгаврын дагуу, гэрээний хавсралтад заасан эд хөрөнгийг хүлээн авч нөхөн сэргээлтийг үнэлж Захиалагч болон гүйцэтгэгчийн эрх үүрэг, нөхцөл төлбөр хэлцлийг тэдгээртэй холбоотой үүсэх бусад харилцааг зохицуулахад гэрээний үүрэг оршино.
- 1.2 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү Гэрээ нь 2024.10.24-2024-12-30 өдрийг дуустал хугацаатай байна.
- 2.2 Гэрээг талууд харилцан тохиролцсоноор, гэрээний үед хэрэг зөрчил гаргах, ажлын байраа орхиж явах үед гэрээг цуцална.
- 2.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл Захиалагчид нэн даруй мэдэгдэж Захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3. Ажил үйлчилгээний төлбөр хөлс

- 3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын төлбөр:
Мод бут тарих, орчныг нөхөн сэргээх ажлын нийт төлбөр тооцоо : Нөатгүй,
Нөаттай 5,215,000 төгрөг байна.
- 3.2 Ажил гүйцэтгэгч нь Хавсралт I-т заасан ажлуудыг цаг тухай бүрт нь гүйцэтгэх бөгөөд Захиалагчид ажлыг тухай бүрт нь тайлагнана.
- 3.3 Захиалагч гүйцэтгэгчид түлш үнэгүй хангах ба усыг өвлийн улиралд төлбөрийг нь гаргаж өгнө.

- 3.4 1-2 хоногт багтаан гүйцэтгэгчийн Хаан банкны ТАДАОТ ХХК 5131166675 дансанд шилжүүлнэ.

4. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1 Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.
- 4.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүн тайланг гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.
- 4.3 Жилд 1 удаа сувилалд эмчлүүлэх сувилуулах боломжоор хангана.
- 4.4 Хавар намар өвлийн улиралд түлшээр хангана. Усны төлбөрт анхаарч ажиллана.
- 4.5 Гэрээ дулаалах, буйраа сэлгэхэд тусална.
- 4.6 Иргэд байгууллага ирж мод тарих үед урьдчилан мэдэгдэж үүрэг өгнө.
- 4.7 Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсанаас хойших аливаа эрсдэлийг харилцан тохиролцсоны дагуу Гүйцэтгэгчтэй хамтран засч залруулах арга хэмжээ авна.
- 4.8 Эд материал мод бутыг хөрөнгийг акт хавсралт үйлдэн хүлээлгэж өгнө.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид ажлаа тайлагнах хүлээлгэж өгөх үүрэгтэй.
- 5.2 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг биечлэн гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.3 Ариун цэвэр хогны асуудлыг байгальд ээлтэй байлгана.
- 5.4 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг харилцан тохиролцсоны үндсэн дээр Захиалагчтай хамтарч засч залруулах арга хэмжээ авна.
- Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасаны дагуу шаардах эрхтэй.
- 5.5 Ажил үйлчилгээний даалгаварын талаархи аливаа мэдээллээр хангагдах эрхтэй.

6. Бусад заалт

- 6.1 Талууд энэхүү 2% гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Талууд Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
- 6.4 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7. Талууд

Гүйцэтгэгч: **ТАДАОТ**

Байгууллага: **ТАДАОТ**

1117245155 6196632

Овог нэр: О.Алтансүвд

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Утасны дугаар: 99997365

Захиалагч:

Байгууллага:

Овог нэр: Г.Ган-Эрдэнэ

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг

Утасны дугаар: 99093350

Хавсралт 1.

Нийлүүлэх мод бутны үнийн санал болон жагсаалт :

№	Эд материал	Үнэ	Хэмжээ	Нийт үнэ	
1.	Гацуур	150,000₮	8 ш	1,200,000₮	
2.	Хайлаас	1,800₮	200 ш	360,000₮	
3.	Бүйлс	9000₮	20 ш	180,000₮	
4.	Гүйлс	8000₮	20 ш	160,000₮	
5.	Голт бор	8000₮	20 ш	160,000₮	
6.	Монос	8000₮	20 ш	160,000₮	
7.	Чацаргана	3,500₮	50 ш	175,000₮	
8.	Үхрийн нүд	12,000₮	10 ш	120,000₮	
9.	Элс	45,000₮	20 куб	900,000₮	
10.	Мод тарилт	9,000₮	140 ш	1,260,000₮	
11.	Мод тарилт /хайлаас/	2,000₮	200 ш	400,000₮	
12.	Хүргэлт	140,000₮	1	140,000₮	
13.	Нийт дүн			5,215,000₮	

Зураг 10. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулсан мод нийлүүлэх, тарих гэрээ

ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Сонгинохайрхан дүүргийн 34-р хорооны нутаг дэвсгэрийн Баянгол аманд байрлах булаг шандыг хашин хамгаалах, тохижуулах	Булагийн эх хамгаалах	Баянгол аманд байрлах булаг шанд	7000.0	2024 онд	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Нийт			7000.0		



НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАНЫ
ДАГУУ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН 34-Р ХОРООНЫ БАЯНГОЛ АМАНД БАЙРЛАХ БАЯНГОЛ
БУЛАГИЙН ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН



Танилцсан: ХБОБНХ-ийн дарга О. Тэмүүжин

Танилцсан: ХБОБНХ-ийн нөхөн сэргээлт
хариуцсан мэргэжилтэн С. Сүхцэож

Улаанбаатар хот
2024он

Зураг 11. Дүйцүүлэн хамгаалал хийсэн тайлангийн нүүр

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажлын үндэслэл

Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малталтын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд тухайн орон нутагт байрлах булаг шандын эхийг шинээр хашиж хамгаалах, сэргээн засварлаж тохижуулах ажлыг хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөгөөний дагуу Жи Эс Эн Ди ХХК, Мон Фрукт ХХК, Сүр Сүлд ХХК-аас хамтран уг ажлыг хийж гүйцэтгэв.

Төлөвлөгөө

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 34-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Баянголын амны “Баянгол” булгийг хашин хамгаалах, орон нутгийн иргэдэд ээлтэйгээр тохижуулах ажлыг хийж гүйцэтгэх.

Ажлын зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажлыг Сонгинохайрхан дүүргийн 34-р хорооны нутаг дэвсгэрийн Баянгол аманд байрлах булаг шандыг хашин хамгаалах, тохижуулах зорилгоор дараах ажлыг төлөвлөн ажилласан.

Үүнд:

1. Өмнө буюу 3-н жилийн өмнө хийгдсэн хайсны эвдэрч гэмтсэн хэсгийг шинэ хайсаар хийж солих.
2. Хайсыг сэргээн засаж гагнуурын ажлыг хийж гүйцэтгэх.
3. Хайсын өнгийг сэргээх, зэврэлтээс хамгаалахын тулд будах.
4. Булгийг хөндлөнгийн бохирдлоос сэргийлэн автомашинтай иргэдэд зориулан зогсоолын тэмдгийг байршуулан зогсоолыг байгуулах.
5. Оршин суугчдад ээлтэй байдлаар орчны тохижилт хийх.
